СҮЛД-АУДИТ ХХК

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Бага тойруу 8 дугаар хороо, 11-р
хороолол GB-центр #502 тоот
Утас:(976) 93098181, 99114056
E-mail: info@suld-audit.mn

2023.03.29 № 23/23
танай _____ -ны № _____

"ГРИЙН ИНВЕСТМЕНТ ББСБ" ХХК-ийн
ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧДЭД

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Санхүүгийн тайлангийн талаарх аудитын тайлан

Санал дүгнэлт

Бид "Грийн Инвестмент ББСБ" ХХК (цаашид "Компани" гэх)-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ээрх санхүүгийн байдлын тайлан, тайлант жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан бүхий санхүүгийн тайлангууд, эдгээр санхүүгийн тайлантай холбоотой нэмэлт тайлбар тодруулга болон нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр хавсаргасан санхүүгийн тайлангууд нь "Грийн Инвестмент ББСБ" ХХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болсон жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан болон мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-д нийцүүлэн эрх бүхий байгууллагын батлсан холбогдох заавар, журмын дагуу үнэн зөв бодитой илэрхийлэгдсэн байна.

Дүгнэлтийн Үндэслэл

Бид аудитаа Аудитын олон улсын стандарт (АОУС)-ын дагуу хийсэн. Эдгээр стандартын дагуу хүлээх хариуцлагаа энэхүү тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт харуулсан. Бид Монгол Улсын аудитын тухай хуулиар санхүүгийн тайлангийн аудитад тавигддаг ёс зүйн шаардлагын дагуу ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн. Бидний олж авсан аудитын баримт нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай, зохистой үндэслэл болно гэж үзэж байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудлууд гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлийн хүрээнд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлсэн асуудлууд байдаг. Эдгээр асуудлыг бид санхүүгийн тайлангийн аудитын агуулгын хүрээнд бүхэлд нь болон энэ

тайлангийн талаар аудиторын дүгнэлт гаргахад авч үзсэн бөгөөд аудитор эдгээр асуудлаар тусад нь дүгнэлт өгдөггүй.

Бусад мэдээлэл

Удирдлага нь бусад мэдээллийн хувьд үүрэг, хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэл гэдэгт санхүүгийн тайланд орсон мэдээллийг хамруулж ойлгох ба санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт нь бусад мэдээллийг хамрахгүй бөгөөд үүнд бид ямар нэгэн баталгаажуулалт илэрхийлэхгүй юм.

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГУУДТАЙ ХОЛБООТОЙ УДИРДЛАГЫН ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

Удирдлага нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу бэлтгэж, үнэн зөв шударгаар толилуулах болон залилан юмуу алдаанаас үүдэлтэй материаллаг алдаанаас ангид санхүүгийн тайлан бэлтгэхэд зайлшгүй шаардлагатай тийм дотоод хяналтыг удирдлагаас тодорхойлох үүрэг хариуцлага хүлээнэ.

Санхүүгийн тайлан бэлтгэхдээ удирдлага нь тасралтгүйгээр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх, компанийн чадамжийг үнэлж, тодруулах шаардлагатай бол компанийг татан буулгахаар, эсвэл ингэхээс өөр бодит хувилбар байхгүйгээр төлөвлөснөөс бусад тохиолдолд тасралтгүй ажиллагаатай холбоотой асуудал болон нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй ажиллагааны зарчмыг ашиглах үүрэг хариуцлага хүлээнэ. Компанийн засаглах удирдлага нь санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүргийг хүлээнэ.

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТАД АУДИТОРЫН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

Бидний зорилго бол санхүүгийн тайлан нь бүхэлдээ залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй бэлтгэгдсэн эсэх талаар хамгийн боломжит баталгааг олж авах, өөрийн дүгнэлтийг илэрхийлсэн аудиторын тайланг бэлтгэх юм. Хамгийн боломжит баталгаа гэдэг нь дээд түвшний баталгаа боловч АОУС-ын дагуу хийж гүйцэтгэсэн аудит нь оршин байгаа буруу тайлагнал бүрийг үргэлж илрүүлнэ гэсэн баталгааг өгдөггүй. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас гарах бөгөөд хэрэв тэдгээр нь дангаараа болон нийлбэр дүнгээрээ санхүүгийн тайлангуудад үндэслэн хэрэглэгчдийн гаргах эдийн засгийн шийдвэрт ул үндэстэйгээр нөлөөлөх бол материаллаг гэж үзнэ.

ТАЙЛАНГИЙН ХЭРЭГЛЭЭ

Энэхүү тайланг Монгол Улсын “Компанийн тухай хууль”-ийн 94 дүгээр зүйлд заасан хуулийн этгээд болох хувьцаа эзэмшигчдийн хүсэлтийн дагуу зөвхөн компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

Хүндэтгэсэн,
Сүлд-Аудит ХХК
Гүйцэтгэх Захирал, /МНБ/ Ч.ГҮНДБАЯР

“Сүлд-Аудит” ХХК
УГК0322
2867656

"ГРИЙН ИНВЕСТМЕНТ ББСБ" ХХК-ИЙН АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2022 оны 12 дугаар сарын 31-нээрх

(төгрөгөөр)

Үзүүлэлтүүд	2021/12/31	2022/12/31
1. Эргэлтийн хөрөнгө		
Мөнгөн хөрөнгө	613,327,019.54	415,587,037.19
Богино хугацаат хөрөнгө оруулалт		
Зээл цэврээр	4,224,088,433.48	5,183,786,007.24
Бусад авлага	929,971,663.85	856,849,382.14
Бусад хөрөнгө	465,264,660.70	553,030,760.32
Эргэлтийн хөрөнгийн дүн	**6,232,651,777.57**	**7,009,253,186.89**
2. Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	**633,605,965.13**	**366,176,499.32**
Барилга байгууламж	447,400,000.00	-
Барилга байгууламжын хуримтлагдсан элэгдэл	(64,001,779.26)	-
Тавилга, эд хогшил	30,647,778.64	36,971,678.64
Тавилга, эд хогшлын хуримтлагдсан элэгдэл	(13,083,958.03)	(16,257,260.15)
Техник хэрэгсэл	313,440,000.00	469,240,000.00
Техник хэрэгслийн хуримтлагдсан элэгдэл	(80,796,076.22)	(123,777,919.17)
Биет бус хөрөнгө	18,111,861.31	26,341,104.01
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	**651,717,826.44**	**392,517,603.33**
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	**6,884,369,604.01**	**7,401,770,790.22**
3. Богино хугацаат өр төлбөр		
Хуримтлуулж тооцсон үнэт цаасны хүүгийн өглөг	-	-
Бусад өглөг	6,336,300.99	69,465,259.87
Богино хугацаат өр төлбөрийн дүн	**6,336,300.99**	**69,465,259.87**
4. Урт хугацаат өр төлбөр		
Банк,санхүүгийн байгууллагаас авсан урт хугацаат зээл	83,535,127.29	53,177,849.10
Урт хугацаат өр төлбөрийн дүн	**83,535,127.29**	**53,177,849.10**
Нийт өр төлбөрийн дүн	**89,871,428.28**	**122,643,108.97**
5. Эздийн өмч		
Энгийн хувьцаа	3,000,000,000.00	3,000,000,000.00
Хандивын капитал	6,787,530.91	6,787,530.91
Хуримтлагдсан ашиг/алдагдал	3,787,710,644.82	3,787,710,644.82
Тайлант үеийн ашиг/алдагдал	-	484,629,505.52
Эздийн өмчийн дүн	**6,794,498,175.73**	**7,279,127,681.25**
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	**6,884,369,604.01**	**7,401,770,790.22**

Хавсаргасан тэмдэглэлүүд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

"ГРИЙН ИНВЕСТМЕНТ ББСБ" ХХК-ИЙН АУДИТ ХИЙГДСЭН ОРЛОГЫН ТАЙЛАН

2022 оны 12 дугаар сарын 31-нээрх

(төгрөгөөр)

Үзүүлэлтүүд	**2022/12/31**
Хүүгийн орлого	1,091,880,204.30
Хүүгийн зардал	10,410,221.80
Цэвэр хүүгийн орлого	**1,081,469,982.50**
Арилжаа болон ханшийн тэгшитгэлийн зөрүү	147,796,776.40
Бусад үйл ажиллагааны орлого	201,902,308.00
Хүүгийн бус орлогын нийт дүн	**349,699,084.40**
Үндсэн үйл ажиллагааны нийт орлогын дүн	**1,431,169,066.90**
Арилжаа болон ханшийн тэгшитгэлийн зардал	-
Боловсон хүчний зардал	221,241,563.00
Бусад зардал	233,776,958.50
Хүүгийн бус зардлын дүн	**455,018,521.50**
Зээлийн эрсдэлийн зардал	134,785,992.60
Найдваргүй авлагын нөөц	-
Үндсэн үйл ажиллагааны ашиг/алдагдал	**841,364,552.80**
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	-
Үндсэн бус үйл ажиллагааны зардал	287,607,325.80
Үндсэн бус үйл ажиллагааны ашиг/алдагдал	**287,607,325.80**
Татвар төлөхийн өмнөх цэвэр ашиг/алдагдал	**553,757,227.00**
Орлогын татварын зардал	69,127,721.50
Тайлант хугацааны цэвэр ашиг/алдагдал	**484,629,505.52**

Хавсаргасан тэмдэглэлүүд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.



"ГРИЙН ИНВЕСТМЕНТ ББСБ" ХХК-ИЙН АУДИТ ХИЙГДСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2022 оны 12 дугаар сарын 31-нээрх

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Хувьцаат капитал	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	**3,000,000,000.00**	**6,787,530.90**	**3,787,710,644.80**	**6,794,498,175.70**
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Залруулсан үлдэгдэл				
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт / бууралт				
Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний өсөлт / бууралт				
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
Тайлант үеийн цэвэр ашиг				
Ногдол ашиг				
Хувьцаат капиталын өсөлт				
2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	**3,000,000,000.00**	**6,787,530.90**	**3,787,710,644.80**	**6,794,498,175.70**
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Залруулсан үлдэгдэл				
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт / бууралт				
Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний өсөлт / бууралт				
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
Тайлант үеийн цэвэр ашиг			484,629,505.50	**484,629,505.50**
Ногдол ашиг				
Хувьцаат капиталын өсөлт				
2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	**3,000,000,000.00**	**6,787,530.90**	**4,272,340,150.30**	**7,279,127,681.30**

Хавсаргасан тэмдэглэлүүд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно

"ГРИЙН ИНВЕСТМЕНТ ББСБ" ХХК -ИЙН АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2022 оны 12 дугаар сарын 31-нээрх

(төгрөгөөр)

№	Үзүүлэлтүүд	2022/12/31
1	**Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ**	
1.1	**Мөнгөн орлогын дүн (+)**	**1,377,296,737.60**
	Зээлийн хүүгийн орлого	1,148,945,575.30
	Банкин дахь хадгаламжийн хүүгийн орлого	26,448,854.30
	Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	179,311,746.40
	Бусад мөнгөн орлого	22,590,561.70
1.2	**Мөнгөн зарлагын дүн (-)**	**603,652,713.90**
	Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлийн хүүгийн зардал	**10,410,221.80**
	Үндсэн ба нэмэгдэл цалин	144,071,978.10
	Ажилтнуудад олгосон нөхөн олговор	20,000,000.00
	Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын зардал	41,843,511.00
	Ашиглалтын зардалд төлсөн мөнгө	26,397,250.40
	Шатахуун, холбоо, интернет сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө	15,079,690.50
	Бичиг хэрэг, ариун цэврийн зардал	2,630,548.60
	Татвар, даатгалын төлсөн мөнгө	28,133,633.50
	Зээл болон түүнтэй холбоотой авлагыг барагдуулахтай холбоотой гарсан мөнгө	20,715,526.10
	Аудитын төлбөр, мэргэжлийн зөвөлгөө үйлчилгээний мөнгө	1,300,000.00
	Зохицуулалтын үйлчилгээний хураамжид төлсөн мөнгө	3,240,000.00
	Бусад үйлчилгээнд төлсөн мөнгө	289,830,354.00
2	**Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн**	
2.1	**Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн**	**8,708,086,999.20**
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	
	Бусад	8,708,086,999.20
2.2	**Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн**	**9,679,471,005.20**
	Баяр ёслол	9,690,077.00
	Хөрөнгө данснаас хассаны гарз	
	Бусад	9,669,780,928.20
3	**Бүх цэвэр мөнгөн гүйлгээ**	(197,739,982.40)
4.1	**Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл**	**613,327,019.50**
4.2	**Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл**	**415,587,037.20**

Хавсаргасан тэмдэглэлүүд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

SULD-AUDIT СҮЛД-АУДИТ ХХК